



**СҮХБААТАР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 17

Баруун-Урт

**Г “SCHOOL POLICE” ЭРГҮҮЛИЙН АЖИЛЛАХ
ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Ерөнхий боловсролын сургууль, түүний орчинд сурагчид гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөж хохирох болон сургуулийн орчинд нийтийн хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сурагчдын эцэг эхийг татан оролцуулж “SCHOOL POLICE” эргүүлийг Ерөнхий боловсролын сургуулийн орчинд ажиллуулсугай.

Хоёр: “SCHOOL POLICE” эргүүлийн ажиллах журмыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Гурав: “SCHOOL POLICE” эргүүлийг мэргэжлийн удирдлагаар хангаж эргүүлийн явц, үр дүнгийн талаар улиралд нэг удаа Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд танилцуулж байхыг Цагдаагийн газрын дарга /цагдаагийн хурандаа Ж.Батбаатар/-д даалгасугай.

Дөрөв: Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Баруун-Урт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргад үүрэг болгосугай.



Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2016 оны 03 сарын 31-ны өдрийн
12. дугаар тогтоолын хавсралт

**СУРГУУЛИЙН ОРЧИНД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ
“SCHOOL POLICE” ЭРГҮҮЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Ерөнхий боловсролын сургууль, түүний орчинд сурагчид гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөх, нийтийн хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажилд сурагчдын эцэг эхийг татан оролцуулах замаар эргүүл зохион байгуулахад оршино.
- 1.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйл “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах”, 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх хэсэг “Иргэдийг нийтийн эргүүлд гаргах” гэсэн заалтыг тус тус үндэслэн Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Ерөнхий боловсролын сургууль болон түүний орчинд сурагчдын эцэг эх /асрах хамгаалагч, харгалзан дэмжигч/-ийг эргүүлд ажиллуулахад энэхүү журмыг удирдлага болгоно.
- 1.3. Сургуулийн орчинд “School police” эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа иргэнд ажил олгогч байгууллага хагас өдрийн цалинтай чөлөө олгоно.

Хоёр: Удирдлага зохион байгуулалт

- 2.1. Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага нь сургууль болон түүний орчинд ажиллах “School police” эргүүлийн үйл ажиллагааг өдөр тутмын удирдлага зохион байгуулалтаар хангаж хяналт тавин, тасралтгүй явагдах нөхцлийг хангаж ажиллана.
- 2.2. Ерөнхий боловсролын сургуулийн захирал тухайн хичээлийн жилд сургуулийн орчинд эргүүлийн үүрэг гүйцэтгэх сурагчдын эцэг эх /асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-ийн хуваарийг гаргаж батлан эргүүлд ажиллах иргэдэд урьдчилан 10 хоногийн өмнө мэдэгдэнэ. Эргүүлийн хуваарийг хичээлийн өглөөний ээлж /07.30-13.30 цаг/, өдрийн ээлж /13.30-19.30 цаг/-т тус бүр 2-оос 4 хүн гарахаар зохион байгуулна.
- 2.3. Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага сургуулийн удирдлага, эргүүлд ажиллаж байгаа сурагчдын эцэг эх /асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-д мэргэжил, аргазүйн дэмжлэг туслалцаа үзүүлж, гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэлд шуурхай очиж ажиллана.

**Гурав: Эргүүлийн үйл ажиллагаа, тавигдах
шаардлага, хориглох зүйл**

- 3.1. Сургууль болон түүний орчинд ажиллах “School police” эргүүлд 20 насанд хүрсэн, согтууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглээгүй, сэтгэцийн өвчингүй, эргүүлийн үүрэг гүйцэтгэх эрүүл мэндийн чадвартай эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг урьдчилан гаргасан хуваарийн дагуу ажиллуулна.
- 3.2. Эргүүлийн үүрэг гүйцэтгэх иргэн энэхүү журамтай урьдчилан танилцаж сургуулийн нийгмийн ажилтан, жижүүр багшаас зааварчилгаа авч “School police” гэсэн хантаазыг өмсөж эргүүлд ажиллана.
- 3.3. Эргүүлд ажиллаж байгаа иргэн дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
 - а/ Сургуулийн бүсэд сурагчдыг гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хөдөлгөөнт эргүүлийн үүрэг гүйцэтгэнэ.
 - б/ Хичээл орох болон тарах цагуудад сурагчдыг сургуулийн орчинд байгаа /сургуулийн бүсэд хамаарах/ замын хөдөлгөөнд аюулгүй оролцоход дэмжлэг вэвлүүлнэ.

в/ Хичээлийн завсарлагаанаар сургуулийн орчинд болон сургууль дотор эргүүлийн үүрэг гүйцэтгэж Монгол Улсын хууль тогтоомж болон сургуулийн дүрэм журмыг мөрдөх талаар шаардлага тавьж ажиллана.

г/ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургуулийн зүгээс болон Хууль сахиулах байгууллагаас зохион байгуулж буй ажил, арга хэмжээнд идэвхитэй оролцно.

д/ Сургуулийн удирдлага, анги даасан багштай харилцан тохиролцсоны үндсэн дээр сурагчдад хууль тогтоомж, мэргэжлээ сонгох зэрэг чиглэлээр яриа таниулга хийж болно.

е/ Эргүүлийн үүрэг гүйцэтгэх хугацаанд сургуулийн орчинд гэмт хэрэг, захиргааны зөрчил гарсан тохиолдолд мэдээллийг Цагдаагийн байгууллагад нэн даруй мэдээлнэ.

ё/ Сургуулийн орчинд бусдыг дарамталдаг, мөнгө төгрөг, эд зүйл авдаг гэх зэргээр гэмт хэрэг зөрчилд холбогдох болзошгүй эрсдэлтэй бүлгийн хүүхдүүдийн талаар олж мэдсэн даруйд Цагдаагийн байгууллагад мэдэгдэх.

ж/ Сургуулийн орчны Цахим тоглоомын газруудад хяналт тавьж ажиллана, илэрсэн зөрчлийг Цагдаагийн байгууллага холбогдох албан тушаалтанд мэдээлэх.

и/ Эргүүлийн үүрэг гүйцэтгэгэх хугацаанд "School police" хантаазыг бохирдуулж, гэмтээхгүй өмсөж хэрэглэж эргүүлийн үүрэг гүйцэтгэх хугацаа дуусахад ажилласан талаарх илтгэх хуудсыг бичиж хантаазын хамт сургуулийн нийгмийн ажилтан болон жижүүр багшид өгнө.

- 3.4. Эргүүлд ажиллаж байгаа иргэн үүрэг гүйцэтгэх хугацаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж иргэд, хүүхдүүтэй зөв боловсон харьцах ба төрийн байгууллагын ажилтны нэр барьж хууль бус үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 3.5. "School police" эргүүлд ажиллах иргэн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр таслахыг хориглох бөгөөд хэрэв хуваарийн дагуу эргүүлд ажиллах боломжгүй болсон тохиолдолд энэ талаар сургуулийн удирдлагад З хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

Дөрөв: Бусад зүйл, хариуцлага

- 4.1. Эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа иргэн үүрэг гүйцэтгэх хугацаандаа халдлагад өртсөн тохиолдолд Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн /22-р зүйлийн/ холбогдох заалтын дагуу төрөөс хохирлыг барагдуулна.
- 4.2. Эргүүлийн үүрэг гүйцэтгэхээс санаатай зайлсхийсэн тохиолдолд Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт /Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас харьяа нутаг дэвсгэртээ бүх нийтээр дагаж мөрдүүлэхээр хууль тогтоомжийн дагуу гаргасан шийдвэрийг зөрчсөн бол/ заасны дагуу торгуулийн арга хэмжээ ногдуулна.

* * * * *

Цагдаагийн байгууллагаас гаргасан судалгаагаар хүүхдийг сургуулийн ойр орчимд, сургуулиас гэр хүрэх замд нь айлан сүрдүүлж, гар утас, цүнх зэрэг үнэ бүхий эд зүйлсийг нь дээрэмдэх, булааж зугтаах гэмт хэрэг, замын хөдөлгөөний аюулгүй байдал зөрчигдэж, осол аваарт өртөх зэрэг хичээлийн жил эхэлсэнтэй холбогдуулан сургуулийн насны хүүхэд хохирогч болох нь олширдог. Иймээс сургуулийн орчинд үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс нийслэлийн цагдаагийн газраас "School police" төслийг зохион байгуулахаар ажиллаж байна. Энэхүү төсөл нь эцэг, эхчүүд жилдээ нэг удаа хүүхдийнхээ сургуулийн орчинд эргүүл хийснээр хүүхдүүд гэмт хэрэгт өртөхгүй, хохирохгүй байх орчинг бүрдүүлэх гол ач холбогдолтой юм. Мөн эцэг эхчүүдэд хүндрэл чирэгдэл багатай, хүүхдүүд аюулгүй орчинд байх нөхцөл бололцоог бүрдүүлж байгаа юм. Цагдаагийн албаны эргүүл, гэрэлтүүлэгтэй, камержуулсан гудамж талбай, нийтийн эзэмшлийн орчинд гэмт хэрэг, зөрчил бага гардаг шиг зохион байгуулалттай эцэг эхчүүдийн эргүүл гарснаар тухайн сургуулийн орчинд аюулгүй орчин бүрдэх юм.

БАТЛАВ:
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА Ж.БАТБААТАР

“SCHOOL POLICE” АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖИЛЛУУЛАХ
ТӨЛӨВЛӨГӨӨ

2015.12.10

Баруун-Урт сум

Зорилго: Ерөнхий боловсролын сургууль, түүний орчинд сурагчид гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөх, хэв журам зөрчигдэхөөс урьдчилан сэргийлэх ажилд сурагчдын эцэг эхийг татан оролцуулах замаар эргүүл зохион байгуулах.

Хугацаа: 2015 оны 10 сарын 01-ээс 2016 оны 05 сарын 25 хүртэл.

Зохион байгуулах ажил:

1. “SCHUUL POLICE” эргүүлийн ажиллах журам боловсруулан Аймгийн ГХУССЗ-өөр батлуулах.
 - a. Хариуах эзэн: м НХЖХТ-ийн дарга, цагдаагийн дэд хурандаа П.Лувсандорж, ЗЦТ-ийн дарга, цагдаагийн дэд хурандаа Ч.Уранбор.
b. Хугацаа: 2015 оны 09 сарын 15.
2. “SCHUUL POLICE” эргүүлийн өмсөх хантааз хийлгэх ажлыг зохион байгуулах.
 - a. Хариуцах эзэн: НХЖХТ-ийн дарга, цагдаагийн дэд хурандаа П.Лувсандорж, ЗЦТ-ийн дарга, цагдаагийн дэд хурандаа Ч.Уранбор.
b. Хугацаа: 2015 оны 09 сард
3. “SCHOOL POLICE” эргүүлийн ажиллах журам, зохион байгуулан ажиллах төлөвлөгөөг Бүрэн дунд сургуулиудад хүргүүлэх.
 - a. Хариуцах эзэн: ГБХХ-ийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Ариунтуяа.
b. Хугацаа: 2015 оны 09 сарын 25-ны дотор
4. “SCHUUL POLICE” арга хэмжээний нээлтийн ажиллагааг зохион байгуулах.
 - a. Хариуцах эзэн: ОНХА байцаагч, цагдаагийн ахмад Г.Ганчимэг, ЗЦ-ын ахлах байцаагч, цагдаагийн ахмад Ж.Аэжаргал.
b. Хугацаа: 2015 оны 27.
5. Арга хэмжээний хүрээнд хэрхэн ажиллах талаар эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулж гарын авлага санамж, зөвлөмж тараах.
 - a. Харицах эзэн: ЗЦТ-ийн дарга, цагдаагийн дэд хурандаа Ч.Уранбор, Хэв журмын ахлах байцаагч, цагдаагийн ахмад Б.Саранчимэг
b. Хугацаа: 2015 оны 10 сард
6. Арга хэмжээг орон нутгийн телевизээр сурталчилах.
 - a. Хариуцах эзэн: 2015 оны 09 сарын 27. /цаашид үйл ажиллагааг байнга/
b. Хариуцах эзэн: ОНХӨ байцаагч, цагдаагийн ахмад Г.Ганчимэг
7. Арга хэмжээний явц байдалд хяналт тавьж, зөвлөгөө өгч ажиллах.
 - a. Хариуцах эзэн: ЗЦТ-ийн ахлах байцаагч, цагдаагийн ахмад Ж.Аэжаргал, ОНХА байцаагч, цагдаагийн ахмад Г.Ганчимэг, ГБХХГХ-ээс урьдчилан сэргийлэх ахлах байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Ариунтуяа.
8. 2015-2016 оны хичээлийн жилийн 1-р улиралд хийсэн ажлыг дүгнэн ГХУССЗ-д танилцуулах.
 - a. Хариуцах эзэн: Хариуцах эзэн: ГБХХ-ийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Ариунтуяа.
b. Хугацаа:
9. 2015-2016 оны хичээлийн жилийн 2-р улиралд хийсэн ажлыг дүгнэн ГХУССЗ-д танилцуулах.
 - a. Харинцах эзэн:

- b. Хугацаа:
 - c. 2015-2016 оны хичээлийн жилийн 3-р улиралд хийсэн ажлыг дүгнэн ГХУССЗ-д танилцуулах.
 - d. Хариуцах эзэн:
 - e. Хугацаа:

10. 2015-2016 оны хичээлийн хилд хийсэн ажлыг дүгнэн ГХУССЗ-д танилцуулах.

Хариуцах эзэн: НХЖХТ-ийн дарга, цагдаагийн дэд хурандаа П.Лувсандорж, ЗЦТ-ийн дарга, цагдаагийн дэд хурандаа Ч.Уранбор

а. Хугацаа: 2015 оны 05 сарын 20-ны дотор.

11. 2015-аас 2016 оны хичээлийн "SCHUUL POLICE" арга хэмжээний хаалтын ажиллагааг зохион байгуулан арга хэмжээний хүрээнд идэвхитэй ажилласан эцгээхийн төлөөлөл болон сургуулийг шагнаж урамшуулах.

а. Хариуцах эзэн: НХЖХТ-ийн дарга, цагдаагийн дэд хурандаа П.Лувсандорж, ЗЦТ-ийн дарга, цагдаагийн дэд хурандаа Ч.Уранбор

б. Хугацаа: 2016 оны 05 сарын 25-ны дотор

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:

**ХҮХДИЙН БАЙЦААГЧ, ЦАГДААГИЙН
АХЛАХ ДЭСЛЭГЧ** **Б.АРИУНТУЯА**